



49

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 91 оны 01 сарын 24

№ 85.

Улаанбаатар
хот

Пүүс байгуулах тухай

Нийслэлийн худалдаа, үйлчилгээний соёлын түвшинг дээшлүүлэх, улсын болон хотын валютын санг арвижуулах, шинээр ажлын байр бий болгох талаар гарч байгаа санаачилгыг дэмжин Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны ивээлд ажиллах худалдаа, үйлдвэрлэл-үйлчилгээний "Таван богд" пүүсийг 1991 оны I дүгээр сараас аж ахуйн тосцоон дээр ажиллуулахаар байгуулж, дүрмийг хэвсгалтын ёсоор баталсугай.

2. "Таван богд" пүүсэд үйлдвэрлэл үйлчилгээний байр олгох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хотын орон сууц, нийтийн аж ахуй, эрхэлсэн орлогч дарга /н.Баасанжав/, их барилга хөрөнгө оруулалт хариуцсан орлогч дарга /н.Найдан/-д тус тус даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА 2

Л. ЭНХБИШ

Ч. СУМХУЙ



Улаанбаатар хотын ардын хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 25 дүгээр тогтоолоор батлав.
ХУДАЛЦАА, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "ТАВАН БОГД" ПҮҮСИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Худалцаа, үйлдвэрлэл үйлчилгээний "Таван богд" пүүс нь /цаашид пүүс гэнэ/ Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны ивээл дор нийслэлийн хүн амд хүнс болон үйлдвэрийн бараагаар худалцаа үйлчилгээ хийх, гадаадын зочид жуулчдад зориулж бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж төгрөг болон валютаар худалдах, жуулчны иж бүрэн үйлчилгээ бүхий зочид буудал ажиллуулах зэргээр аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр ажиллах биеэ даасан хуулийн этгээд мөн.

2. Пүүс нь өөрийн үйл ажиллагаагаа БНМАУ-ын хууль тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу явуулна.

3. Пүүс нь мэдэлдээ байгаа эд хөрөнгийг эзэмших, ашиглах, зарцуулах эрхээ хууль тогтоомжоор заасан хэмжээ хязгаарын дотор өөрийн үйл ажиллагаа зорилгын дагуу хэрэгжүүлнэ.

4. Пүүс нь өөрийн нэр бүхий таних тэмдэг /эмблем/, бичгийн хэвлэмэл нүүр, тэмдэгтэй байна.

ХОЁР. Пүүсийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилт

1. Пүүсийн үндсэн үйл ажиллагаа нь нийслэлийн хүн амд худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр хүнс болон үйлдвэрийн бараагаар худалдаа хийх, бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж иргэд болон гадаадын зочид жуулчдад төгрөг, валютаар худалдах, зочид буудал, бар, кофэ ажиллуулж жуулчны иж бүрэн үйлчилгээ явуулахад чиглэгдэнэ.

2. Пүүс аж ахуйн үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ ажилгүйдчүүдийн дунд судалгаа явуулсны үндсэн дээр тэдгээрийн тодорхой хэсгийг тэдний ур чадвар, мэргэжлийн даллага болон нийслэлийнхний эрэлт хэрэгцээг харгалзан ажлын байраар хангах "Зүүнсэлбэ" хорооллын бүтэн, хагас өнчин хүүхдүүд, тахир дутуу иргэдэд өөрийн үйлдвэрлэлийн цэвэр ашгийн тодорхой хэсгээр "ТЭТГЭМЖ" санг байгуулж олон хэлбэрийн материаллаг тусламж үзүүлнэ.

2.

3. Хувь хүмүүстэй хөдөлмөрийн гэрээ байгуулан шаардлагатай нэмэлт үйлчилгээг явуулна.

4. Пүүс нь өөрийгөө хөгжүүлэх найдвартай эдийн засагтай болоход үйл ажиллагаагаа чиглүүлж хөгжингүй орны ажил төрлийн түнштэй болох, харилцан ашигтай хамтран ажиллах, үүний үндсэн дээр үйлдвэрлэлийн дэд бүтэц болон уян хатан тогтолцоо /сис-тем/ бий болгох, электрон техникээр тоноглох, шинжлэх ухааны орчин үеийн технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг зорилт болгоно.

ГУРАВ. Пүүсийн эрх

Тус пүүс нь гадаад худалдааны эрхтэй байх бөгөөд дотоод гадаадын пүүс, нийгэмлэг, үйлдвэр, хоршоолол, аж ахуйн байгууллагуудтай олон улсын болон БНМАУ-ын хууль тогтоомжуудын хүрээнд гэрээ хэлэлцээ хийх, хамтран ажиллах, худалдаа хийх.

1. Улсын төвлөрсөн хангамжаас материал авахдаа улсын үйлдвэрүүдийн адил үнэ эрхтэйгээр авах.

2. Реклам сурталчилгаа явуулах, олон улсын хурал зөвлөлгөөн, яармаг үзэсгэлэнд оролцох.

3. БНМАУ-ын болон олон улсын банканд үндэсний болон чөлөөт валютын данстай байж өөрийн мэдлээр зарцуулах.

4. Пүүсийн үүсгэн байгуулахтай холбогдсон баримт бичгүүд эрх бүхий байгууллагаар батлагдаж улсын бүртгэлд бүртгүүлэн, харилцах данс нээсний дараа зохих тооцоо дүгнэлтийг үндэслэн банкнаас урт богино хугацааны зээл авч, үйлдвэрлэлийн хэрэгсэл, байр, сууц, эд материал бусад зүйлийг худалдан авах буюу түрээслэн авч үйлдвэрлэл явуулах.

5. Тусламж хандив өгөх болон авах эрхтэй.

4. ДӨРӨВ. Пүүсийн удирдлага, зохион байгуулалт

1. Пүүсийг удирдах байгууллага нь пүүсийн үүсгэн байгуулагчид болон үндсэн ажилтнуудаас бүрдсэн пүүсийн зөвлөл мөн. Зөвлөлийн хурлаар пүүсийн дотоод журам, орлого хуваарилах, орон тоо, цалингийн сан, пүүсийн захирал ба бусад албан тушаалтнуудыг хэлэлцэж сонгох, мөн үйлдвэрлэл үйлчилгээтэй холбогдсон бүх асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрийг захирал батлана. Зөвлөлийн хурлыг 60-аас дээш хувийн оролцоотойгоор хийнэ.

2. Пүүсийн өдөр тутмын үйл ажиллагааг пүүсийн зөвлөлөөс сонгогдсон захирал удирдан явуулна.

3. Пүүсийн дотоод бүтэц, дэд салбарын зохион байгуулалтыг зөвлөлийн хурлаас хэлэлцэж пүүсийн захирлын тушаалаар томилно.

4. Пүүсийн захирал нь хэрэв өөр ажилтныг тусгайлан томилоогүй бол гэрээ хэлэлцээ, худалдаа, олон улсын ба дотоод, гадаадын элдэв арга хэмжээнд пүүсийг төлөөлөн оролцож акт тогтоох эрхтэй.

5. Пүүсийн ажилтан, дэд бүтцийн удирдагчид нь албан тушаалын зааврын дагуу ажиллаж пүүсийн хөгжилт, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээний чанарт онцгой анхаарч идэвхтэй ажиллана.

6. Пүүс нь өөрийн харьяанд хоршоолол, зуучийн алба мэтийг өөрийн эдийн засгийн бололцоонд туншиглан зохион байгуулан ажиллуулж болно.

ТАВ. Пүүсийн ажилтан

1. Пүүсийн ажиллагсад нь 18 насанд хүрсэн БНМАУ-ын болон гадаад орны иргэд байж болно. Пүүсийн ажиллагсдыг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулна. Ажиллагсдыг дотор нь үндсэн ажилтан, туслах үйлдвэрлэл-үйлчилгээний ажилтан, түр гэрээгээр ажиллагсад гэж 3 үндсэн ангид хамааруулна.

2. Пүүсийн үндсэн ажилтнаар тодорхой мэргэжил эзэмшсэн тухайн үүрэгт ажлыг хийж гүйцэтгэж чадах итгэл бүхий эрүүл мэнд сайн, гадаад хэлний зохио боловсролтой, үйлдвэрлэл-техникийн дадлага туршлагатай ажилтныг сонгон шалгаруулах журмаар элсүүлнэ. Пүүсийн үндсэн ажилтны тоо нь үйлдвэрлэлийн болон эдийн засгийн хүчин чадлаас шалтгаална.

3. Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнаар гэрээний үндсэн дээр ажил үүрэг гүйцэтгэж чадах иргэдийг авч ажиллуулна.

Үүнд: Бар, кафе, зочид буудал, дэлгүүр, туслах үйлдвэр, бусад дэд бүтэцийн ажилтнуудийг хамааруулна.

4. Түр гэрээгээр ажиллагсад нь улирлын, барилга засварын тоног төхөөрөмжийг бүтээх, угсарахад оролцох төрөл бүрийн мэргэжлийн ажилчид, оюутан сурагч, цагаан ажиллагсад, гадаадын мэргэжилтэн нар болно. Орон тооны бус ажиллагсад нь техникийн болон хуулийн зөвлөх, хөдөө аж ахуйн зөвлөх, эмгөөлөгч, амч, мэдээллийн ажилтан гэх зэрэг болно.

4.

5. Пүүсийн ажиллагсад нь тус пүүсийн зорилго, хэтийн төлөв, ажиллагааны онцлогийг ойлгож, нийгмийн баялагийг бүтээн гэрээнд дурдсан ажлыг гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд өөрийн хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс авах эрхийг эдэлнэ.

6. Пүүсийн үндсэн ажилтныг /үүсгэн байгуулагчдад хамаарахгүй/ 3 сар, туслах үйлдвэр-үйлчилгээний ажилтныг 2 сар, түр гэрээгээр ажиллагсацыг шууд, тус тус туршилтын /дагалдаж дадлага хийх/ хугацаагаар авч цаашид ажиллах найдвартайгаа харуулбал хөдөлмөрийн гэрээ хийж ажиллуулна.

7. Пүүсийн ажилтнаар авах буюу чөлөөлөгдөх нь пүүсийн захирлын тушаалаар хэрэгжинэ. Энэ нь ажилтны санаанд эс нийцвэл пүүсийн зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх бөгөөд энэ нь эцсийн шийдвэр болно.

8. Пүүсийн ажилтан бүр үнэнч шударга хөдөлмөрлөх, дотоод дэг журмыг сахин биелүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээд хэмжээнд байлгах, технологийн сахилгыг чанд мөрдөх, өмч хөрөнгөд өөриймсөг хандаж, аж ахуйч бус байдалтай тэмцэх үндсэн үүрэгтэй.

ЗУРГАА. Пүүсийн эд хөрөнгө, санхүү эдийн засгийн үйл ажиллагаа

1. Пүүсийн эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгөнөөс бүрдэнэ.

2. Пүүсийн худалдаа, үйлдвэрлэл-үйлчилгээний орлого нь кафе, бар, зочид буудал, нэрийн барааны дэлгүүр, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, бусад ажил үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

3. Бараа материал, түүхий эдийн хангамжийн асуудлыг тухайн жил аж ахуйн гэрээний үндсэн дээр шийдвэрлэнэ.

4. Үйлдвэрлэлийг шинээр нээх, өргөтгөх болон түүхий эд материал тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслэлээр хангах /эргэлтийн хөрөнгөө бүрдүүлэх/ зориулалтаар урт богино хугацааны эзэл авч тэдгээрийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан уг зээлийг хүүгийн хамт хугацаанд нь төлнө.

5. Тайланг улсын батлагдсан маягтын дагуу сар, улирал, жилээр гаргаж холбогдох байгууллагад тайлагнана.

6. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлогыг тогтсон журмын дагуу хуваарилна.

7. Үйлдвэрлэлийн орлого болон сэргээн босголтны фондын хөрөнгөнөөс зээлийг төлөх бөгөөд зээлийн хүүг зээлдүүлэгч байгуулагатай тооцно.

8. Зээлийн өрийг төлж дууссаны дараа үйлдвэрлэлийн хэрэгсэл буюу бусад хөрөнгө нь нүүсийн хамт олны өмч болно.

ДОЛОО. Нүүсийг өөрчлөн байгуулах, татан буулгах

Нүүсийн үйл ажиллагаа энэ дүрэм ба хууль тогтоомшид нийцэхгүй буюу эдийн засгийн үйл ажиллагаа явуулах чадваргүй болсон тохиолдолд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр /нүүсийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэж болно/ өөрчлөн байгуулах буюу татан буулгана.

Нүүсийг татан буулгахад холбогдох тооцоог хийж Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн газарт бүртгэнэ.